



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/106

Сүхбаатар сум

Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тсгтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Туузан метрээр хэмжилт хийгдэж олгогдсон иргэн Сартуул овогт Гүнгэрэгжавын Буяндорж /МТ73020119/-д 3 дугаар баг Ш.Мөнхбатын 1 дүгээр гудамжны 111 тоот хаягт байршилтай үйлдвэр үйлчилгээний зориулалттай газрыг кадастрын зурагт орсон хэмжээ бүхий 4308004048 нэгж талбарын дугаартай 10693 м² газрын эзэмших эрхийг баталгаажуулсугай.

2. Туузан метрээр хэмжилт хийгдэн анх олгогдсон дээрх газарт кадастрын зураглал хийн, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж, холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд оруулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3. Эзэмшил газрынхаа арваас доошгүй хувьд ногоон байгууламж бүрдүүлэн, тохижуулж, хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн /Г.Буяндорж/-д үүрэг болгосугай.

4. Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Г.Буяндоржийн эзэмшилд олгосон Сүхбаатар сумын Засаг даргын шийдвэрээр олгогдсон 171200003 дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, 171200003 дугаартай гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ